



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗАР**

Бага тойруу 13/1, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 63 32, Факс: (976-11) 32 99 33,
Цахим шуудан: info@cd.gov.mn,
Цахим хуудас: www.cd.gov.mn

2025.08.28 № 02/2201

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Э.БОЛОРМАА ТАНАА**

Таны ирүүлсэн 2025 оны 08 дугаар сарын 19-ны өдрийн УИХ-03/9628 дугаар албан бичгийн дагуу тус байгууллагад иргэд, аж ахуй нэгжээс ирүүлсэн санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой гомдол, мэдээлэл, шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг хүргүүлэв.

Хавсралт ¹... хуудастай.

Хүндэтгэсэн,

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,
ХУРАНДАА

А.НАМСАМАНД

1501083535

МЭДЭЭЛЭЛ

2025 оны 08 дугаар сарын 27

Улаанбаатар хот

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2025 онд иргэд, аж ахуй нэгжээс ирүүлсэн санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой гомдол, мэдээллийн тухай

2025 он тус байгууллагад санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой нийт 4 гомдол ирсэн байна. Хүснэгтээр харуулбал:

	Гомдол гаргагч	Гомдлын утга	Шийдвэрлэлт
1	Иргэн Г.Баатар	“ШТН” ТӨААТҮГ-ын дарга 2024 оны 03 дугаар сард 7.5 сая төгрөг зээлж, байгууллагын дансанд авсан. Одоо дарга нь солигдсон тул миний мөнгө олдохгүй байна.	“ШТН” ТӨААТҮГ-т үүрэг хүргүүлж, төлбөрийг барагдуулсан.
2	Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын багш, дэслэгч М.Буянхишиг, дэслэгч Г.Сайханзаяа нар	Ахлах ахлагч Б.Анхбаярын цалинг тооцоолоходоо 1,178.8 мянган төгрөгийн цалинг дутуу бодож, нөхөж олгосон. Дэслэгч Б.Баасанжаргалын цалинг тооцоолоходоо 530.1 мянган төгрөгийн цалинг дутуу бодож, нөхөж олгосон. Дэслэгч М.Буянхишигийн цалинг тооцоолоходоо 215.0 мянган төгрөгийн цалинг дутуу бодож, нөхөж олгосон.	Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын ахлах нягтлан бодогч, ахлах дэслэгч А.Энхзүлд “Өөрт ганцаарчилсан хэлбэрээр сануулах” арга хэмжээ авсан.
3	Иргэн Б.Ууганцэцэг	409 дүгээр нээлттэй, хаалттай хорих ангид 270.0 мянган төгрөгийн цемент худалдсан боловч мөнгөө аваагүй.	Төлбөрийг шилжүүлсэн нь холбогдох баримтаар тогтоогдсон тул гомдол гаргагчид хариуг хүргүүлсэн.
4	Дархан-Уул аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-445 дугаар нээлттэй хорих ангийн тооцооны нягтлан бодогч, ахлах дэслэгч Н.Эрдэнэчимэг	Тус ангийн Худаг, мод үржүүлгийн хэсэгт байрлах аж ахуйн үйлчилгээнд ажиллаж буй хоригдлуудыг өөр газар хувийн ажилд гаргаж, хөдөлмөрлүүлдэг. Тус ангийн дарга, дэд хурандаа Р.Ууганбаяр нь 500,000 төгрөг ангийн кассаас бэлнээр авсан.	Дархан-Уул аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-445 дугаар нээлттэй хорих ангийн дарга, дэд хурандаа Р.Ууганбаярт “цолны мөнгийг 1 сарын хугацаагаар хасах” сахилгын шийтгэл ногдуулсан.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР